



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/58/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд
тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204

Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 70584207 Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

1020.02.27 № 129

танай -ны № -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520050



Аудитын гол асуудал

Тайлант оны эцэст хөрөнгийн тооллого хийлгүй санхүүгийн тайлан баланс илэрхийлсэн нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2 дахь "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1 дэх "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга, Б.Хонгорзул танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-наас 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 3/31 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас



санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Харьяалах нутаг дэвсгэрийнх нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас батлах төсөл, хөтөлбөрт санал өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах”-д оршино.

Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах
- Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Чойбалсан сумын Засаг даргын тамгын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Axplorer” программ хангамж ашигладаг байна.

Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 21 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.



2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 435,334.3 мянган төгрөгөөс тооцон 8,706.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 12,532.8 мянган төгрөгөөр тооцсон нь зардлын гүйцэтгэл өмнөх оноос өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 944.8 мянган төгрөгөөр буюу 0,2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	516.5	65.1	-451.4
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	257,931.6	256,561.4	-1,370.2
Үндсэн хөрөнгө	1,536,076.9	1,640,884.6	104,807.7
Хуримтлагдсан элэгдэл	-446,582.4	-550,513.3	-103,930.9
Нийт хөрөнгө	1,347,942.6	1,346,997.8	-944.8
Өр төлбөр	3,436.3	-	-3,436.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,344,506.3	1,346,997.8	2,491.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,347,942.6	1,346,997.8	-944.8

Авлага дансны үлдэгдэл 451.4 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь өмнөх оны үлдэгдлээс зарцуулалт хийснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд тусгай зориулалтын 13,754.7 мянган, бичиг хэргийн 2,981.4 мянган, аж ахуйн 53,831.4 мянган, бусад хангамжийн 17,250.0 мянган, 168,733.9 мянган төгрөгийн мал амьтад байна



Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь аймаг сумаас орон нутгийн хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар 29,331.4 мянган төгрөгийн барилга байгууламж, сумын хөрөнгө оруулалтаар 15,000.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 44,691.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө, төсвийн хөрөнгөөр 13,615.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,237.2 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 932.2 мянган төгрөгийн санхүүгийн программ худалдан авснаар нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгө өссөн нь 932,2 мянган төгрөгийн санхүүгийн программ хангамж худалдан авснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3,436.3 мянган төгрөгөөр буурсан өмнөх оны ажиллагсадтай холбоотой татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг барагдуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,346,997.8 мянган төгрөг болж 2,491.4 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 336,050.8 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 336,050.8 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 335,996.2 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Аймгийн Засаг даргын нөөцийн сангаас 750,0 мянган төгрөг, аймгийн Байгаль хамгаалах сангаас 536,5 мянган төгрөг, Статистикийн хэлтэс мал тооллогын 408,6 мянган төгрөг, Цагдаагийн хэлтсээс малчдын зөвлөгөөний зардалд 250,0 мянган төгрөг, Хөдөө аж ахуйн газраас 10,000,0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын тамгын газраас 1,107,3 мянган төгрөг, аймгийн ГБХЗХГ-аас 300,0 мянган төгрөг, аймгийн хөрөнгө оруулалтаас 69,931,1 мянган төгрөг, аймгийн Онцгой байдлын газраас 476,1 мянган төгрөг, түймрийн хохиролд УБ төмөр замаас 865,8 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 6,186,1 мянган төгрөгийг нэмэлт төсвөөр хүлээн авсан байна.

Үүнээс хагас жилийн мал тооллогын шатахууны зардалд 408,6 мянган төгрөгийг, Үлийн цагаан оготно устгалын урамшуулал, шатахуун, багаж хэрэгсэл худалдан авахад 10,000,0 мянган төгрөгийг, Цагдаагийн албан хаагчдын сургалт семинарын зардалд 250,0 мянган төгрөг, нөөцийн өвсний зардалд 5436,4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны зардалд 1424,2 мянган төгрөг, хуучин сургуулийн дотуур байрыг төрийн албан хаагчдын байр болгон завсарлах их засварын зардалд



69,931,1 мянган төгрөгийг, түймрийн шатахууны зардалд 3,361,3 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 21 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 21 эрсдэл тодорхойлж нийт 21 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,358,136.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,100.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,130.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,349,252.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 2,654.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 1,355,036.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд төлбөрийн акт тогтоож, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 650,0 мянган төгрөгийн томилолт олгосон байна. Энэ нь "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог томилолтын үнэмлэхэд тэмдэглэсэн календарийн бүх хоногоор тооцож гаргана. ..." гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Засаг даргын захирамжаар 2480,0 мянган төгрөгийг Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-д хамаарахгүй, урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэгт "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3. Нэмэлт санхүүжилтийн данснаас "Цэнгэлийн зүг" ХХК-д багаж тоног төхөөрөмж худалдан авахаар 2,420.0 мянган төгрөгийг шилжүүлэн, хөрөнгийг хүлээн авснаар бүртгэсэн байна. Гэвч уг хөрөнгө бодитоор оршин байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. дахь хэсэгт "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт "Төсвийн бүртгэлийг тохируулсан аккрузл сууриар бүртгэж, тайлагнана" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх хэсэгт "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" заавал тооллого хийнэ гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, оршин байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 2,654.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Чойбалсан сумын Засаг даргын тамгын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 141 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 800,0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулсан, 5,300.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 100 хувьтай байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалтай” дүгнэлт

Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНБООУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Дотоод хяналтай данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд сумын Засаг дарга албан тушаалын суудлын автомашин хэрэглэн 2,654.1 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.
- 1.2. Эрсдэл: Хөрөнгө арвилан хэмнэлт, үр ашиггүй зарцуулагдах.
- 1.3. Өгсөн зөвлөмж: ЗГ-ын тогтоолыг хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	258448060,78	256 626 488,69
33	АВЛАГА	516464,54	65 092,45
335	Бусад авлага	516464,54	65 092,45
3352	Хувь хүмүүсээс авах авлага	65092,45	65 092,45
35	БАРАА МАТЕРИАЛ	257931596,24	256 561 396,24
351	Түүхий эд материал	13764670,07	13 764 670,07
35110	Тусгай зориулалттай материал	13764670,07	13 764 670,07
354	Хангамжийн материал	75432976,17	74 062 776,17
35410	Бичиг хэргийн материал	2534880,00	2 981 380,00
35420	Аж ахуйн материал	48487092,67	53 831 392,67
35470	Бусад хангамжийн материал	24411003,50	17 250 003,50
35600	Мал амьтад	168733950,00	168 733 950,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1089494553,51	1 090 371 273,55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1089494553,51	1 090 371 273,55
392	Биет хөрөнгө	1038077803,59	1 038 522 598,65
39201	Барилга, байгууламж, орон сууц	421268341,54	465 599 719,54
39202	Хуримтлагдсан элэгдэл	0,00	(16 794 624,69)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	115375825,60	115 375 825,60
39204	Хуримтлагдсан элэгдэл	-100260853,35	(109 545 958,64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47923096,18	61 538 976,18
39206	Хуримтлагдсан элэгдэл	-37029684,25	(41 799 898,13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24794575,00	26 031 775,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13082312,29	(15 068 532,93)
39214	Бусад үндсэн хөрөнгө	873857097,20	918 548 097,20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-294768282,04	(365 362 780,48)
393	Биет бус хөрөнгө	51416749,92	51 848 674,90
39301	Програм хангамж	2400000,00	3 332 200,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1441250,08	(1 941 525,10)
39303	Бусад биет бус хөрөнгө	50458000,00	50 458 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1347942614,29	1 346 997 762,24
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1344506314,38	1 346 997 762,24
51	Засгийн газрын хувь оролцоо	1344506314,38	1 346 997 762,24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	470742769,00	470 742 769,00
51101	Өмч: - төрийн	470742769,00	470 742 769,00
512	Хуримтлагдсан үр дүн	745313560,14	747 805 008,00
51210	Өмнөх үеийн үр дүн	745313560,14	745 313 560,14
51220	Тайлант үеийн үр дүн	0,00	2 491 447,86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	128449985,24	128 449 985,24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1347942614,29	1 346 997 762,24



Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

			/төгрөг/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	413 379 801,00	628 718 950,91
12	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО	63 208 226,00	60 185 000,91
120	Нийтлэг татварын бүс орлого	63 208 226,00	60 185 000,91
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	63 208 226,00	60 185 000,91
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30 000,00	494 000,91
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	63 178 226,00	59 691 000,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	350 171 575,00	568 533 950,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28 110 975,00	90 168 772,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	82 066 552,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28 110 975,00	8 102 220,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	322 060 600,00	478 365 178,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	322 060 600,00	449 033 800,00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	29 331 378,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	435 334 273,28	626 227 503,05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	403 779 823,28	587 465 693,05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	403 648 111,28	532 353 454,05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	202 476 536,00	220 517 896,00
210101	Үндсэн цалин	166 932 160,00	180 403 058,00
210104	Урамшуулал	-	4 251 838,00
210105	Гэрээт ажлын хөлс	35 544 376,00	35 863 000,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26 576 755,91	27 908 132,09
210201	Тэтгэврийн даатгал	19 088 335,91	20 025 685,00
210202	Тэтгэмжийн даатгал	1 833 528,00	1 967 055,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 460 192,00	1 830 354,00
210204	Ажилгүйдлийн даатгал	352 269,00	416 241,00
210205	Эрүүл мэндийн даатгал	3 842 431,00	3 668 797,09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12 240 049,37	14 056 853,00
210301	Гэрэл, цахилгаан	6 716 654,00	8 039 608,00
210302	Түлш, халаалт	5 523 395,37	6 017 245,00
2104	Хангамж, бараа материалын зардал	17 071 650,00	31 027 156,00
210401	Бичиг хэрэг	2 354 920,00	4 644 672,00
210402	Тээвэр, шатахуун	8 555 280,00	17 550 634,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5 775 800,00	3 040 100,00
210404	Ном, хэвлэл	-	59 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	385 650,00	5 732 750,00
2105	Нормативт зардал	303 700,00	992 000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	303 700,00	992 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	16 826 025,00
210602	Тавилга	-	820 750,00
210604	Урсгал засвар	-	16 005 275,00
2107	Томилолт, зочны зардал	4 200 500,00	5 718 000,00
210702	Дотоод албан томилолт	4 200 500,00	5 718 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10 512 869,00	4 725 994,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9 862 869,00	3 439 058,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	600 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	250 000,00	250 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200 000,00	198 936,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150 000,00	88 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	50 000,00	150 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	130 266 051,00	210 581 397,96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35 284 260,00	106 650 460,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	94 981 791,00	103 930 937,96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	131 712,00	55 112 239,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	90 000,00	3 758 000,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9 000,00	2 493 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	81 000,00	1 265 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	41 712,00	51 354 239,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	41 712,00	51 354 239,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31 554 450,00	38 761 810,00
2200	Дотоод эх үүсвэрээр	31 554 450,00	38 761 810,00
223001	Бусад хөрөнгө	31 554 450,00	38 761 810,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(21 954 472,28)	2 491 447,86
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(83 640 308,79)	2 491 447,86



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	375853075,00	540790945,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	203500,00	945373,00
120	Нийтлэг татварын бус орлого	203500,00	945373,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	203500,00	945373,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	203500,00	945373,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	375649575,00	539845572,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53588975,00	90811772,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20110975,00	82066552,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33478000,00	8745220,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	322060600,00	449033800,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	322060600,00	449033800,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	268997282,00	483091245,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	268997282,00	483091245,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	267359562,00	427794006,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204020627,00	220881507,00
210101	Үндсэн цалин	168476251,00	180766669,00
210104	Урамшуулал	0,00	4251838,00
210105	Гэрээт ажлын хөлс	35544376,00	35863000,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21893067,00	31379584,00
210201	Тэтгэврийн даатгал	14953093,00	23491535,00
210202	Тэтгэмжийн даатгал	1695748,00	2001260,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1186300,00	1801185,00
210204	Ажилгүйдлийн даатгал	323242,00	416241,00
210205	Эрүүл мэндийн даатгал	3734684,00	3669363,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11716444,00	15414573,00
210301	Гэрэл, цахилгаан	6716654,00	8575388,00
210302	Түлш, халаалт	4999790,00	6839185,00
2104	Хангамж, бараа материалын зардал	10058655,00	28108784,00
210401	Бичиг хэрэг	2201525,00	4742720,00
210402	Тээвэр, шатахуун	7857130,00	15368214,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0,00	3090100,00
210404	Ном, хэвлэл	0,00	264000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0,00	4643750,00
2105	Нормативт зардал	183900,00	992000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	183900,00	992000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4773500,00	18051900,00
210602	Тавилга	0,00	646300,00
210604	Урсгал засвар	4773500,00	17405600,00
2107	Томилолт, зочны зардал	4200500,00	5768000,00
210702	Дотоод албан томилолт	4200500,00	5768000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10512869,00	4726286,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9862869,00	3439350,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0,00	600000,00
210803	Даатгалын үйлчилгээ	250000,00	250000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200000,00	198936,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150000,00	88000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	50000,00	150000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0,00	102471372,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0,00	102471372,00



Чойбалсан сумын Засаг даргын тамгын газрын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1637720,00	55297239,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1596008,00	3943000,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	81000,00	2493000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1515008,00	1450000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	41712,00	51354239,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	41712,00	51354239,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	106855793,00	57699700,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	39926265,00	57699700,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	39926265,00	57699700,00
2200	Дотоод эх үүсвэрээр	39926265,00	57699700,00
223001	Бусад хөрөнгө	39926265,00	41914420,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0,00	15785280,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-39926265,00	-57699700,00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	420 284 769,00	53 681 726,41	832 086 861,33	1 306 053 356,74
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0,00	0,00	0,00	0,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	420 284 769,00	53 681 726,41	832 086 861,33	1 306 053 356,74
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		74 768 258,83		74 768 258,83
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	50 458 000,00	0,00	0,00	50 458 000,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0,00
C07	Тайлант үеийн үр дүн			-86 773 301,19	-86 773 301,19
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470 742 769,00	128 449 985,24	745 313 560,14	1 344 506 314,38
D01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	470 742 769,00	128 449 985,24	745 313 560,14	1 344 506 314,38
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0,00	0,00	0,00	0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	470 742 769,00	128 449 985,24	745 313 560,14	1 344 506 314,38
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0,00	0,00	0,00	0,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0,00	0,00	0,00	0,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0,00	0,00	0,00	0,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0,00	0,00	0,00	0,00
D08	Тайлант үеийн үр дүн	0,00	0,00	2 491 447,86	2 491 447,86
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470 742 769,00	128 449 985,24	747 805 008,00	1 346 997 762,24



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	450033800,00	356710514,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	407533800,00	356710514,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	403590800,00	352767514,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	259415000,00	220881507,00
210101	Үндсэн цалин	216152000,00	180766669,00
210104	Урамшуулал	6500000,00	4251838,00
210105	Гэрээт ажлын хөлс	36763000,00	35863000,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимт	34926800,00	31379584,00
210201	Тэтгэврийн даатгал	23752200,00	23491535,00
210202	Тэтгэмжийн даатгал	2265600,00	2001260,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2762800,00	1801185,00
210204	Ажилгүйдлийн даатгал	558400,00	416241,00
210205	Эрүүл мэндийн даатгал	5587800,00	3669363,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15540100,00	15414573,00
210301	Гэрэл, цахилгаан	8700000,00	8575388,00
210302	Түлш, халаалт	6840100,00	6839185,00
2104	Хангамж, бараа материалын зардал	28109300,00	27840534,00
210401	Бичиг хэрэг	4744300,00	4742720,00
210402	Тээвэр, шатахуун	15100000,00	15099964,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3200000,00	3090100,00
210404	Ном, хэвлэл	415000,00	264000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4650000,00	4643750,00
2105	Нормативт зардал	1000000,00	992000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1000000,00	992000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26417000,00	26322980,00
210602	Тавилга	9000000,00	8917380,00
210604	Урсгал засвар	17417000,00	17405600,00
2107	Томилолт, зочны зардал	5898400,00	5768000,00
210702	Дотоод албан томилолт	5898400,00	5768000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	19784200,00	12240486,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	10700000,00	3439350,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720000,00	600000,00
210803	Даатгалын үйлчилгээ	250000,00	250000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	250000,00	198936,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200000,00	88000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7664200,00	7664200,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12500000,00	11927850,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12500000,00	11927850,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3943000,00	3943000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3943000,00	3943000,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэвэр	2493000,00	2493000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1450000,00	1450000,00

